

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 12-ны өдөр

Дугаар

БА-024/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 28 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын 6 дугаар цэцэрлэгийн дэргэд 24x17.6м хэмжээтэй, 9м диаметртай 4ш гэр бүхий хүчин чадалтай 100 (нэг зуу) ортой Монгол өв уламжлал, ёс заншлын өргөөний зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 сарын 04-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/03/14 огноо, 0014577 дугаар, БАЗГ-2024/0094;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ЦМЖ-03/22;

2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилгын "Б" блок 5 давхар, 11-324249 холбоо барих утас;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Рино Инженеринг ХХК оноосон нэр, 9011245027 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5397766 регистрийн дугаар, БУ12-778/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Хьюэдэй Элеватор тауэр 501 тоот, холбоо барих утас: 99063201

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: ЦМЖ дизайн консалтинг ХХК оноосон нэр, 9011837068 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6833535 регистрийн дугаар, ЗТ11-377/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 6 дугаар хороо, ЭТӨЧ, Кёкүшю тауэр, 1503 тоот холбоо барих утас: 94990586

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Баянзүрх прогресс ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистрийн дугаар 9096329,

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Хаяг: Улаанбаатар, Баянзүрх, 28-р хороо, Хужирбулан 6-р цэцэрлэг, холбоо барих: 99175807

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын 6 дугаар цэцэрлэгийн дэргэд 24x17.6м хэмжээтэй, 9м диаметртэй 4ш гэр бүхий хүчин чадалтай 100 (нэг зуу) ортой Монгол өв уламжлал, ёс заншлын өргөөний зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.2. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиг
луулах комисс

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох 131 хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын 6 дугаар цэцэрлэгийн дэргэд 24x17.6м хэмжээтэй, 9м диаметртэй 4ш гэр бүхий хүчин чадалтай 100 (нэг зуу) ортой Монгол өв уламжлал, ёс заншлын өргөөний зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ОНӨААТҮГ-ийн захиалгатай, 6 дугаар цэцэрлэгийн дэргэд 24x17.6м хэмжээтэй,
9м диаметртэй 4ш гэр бүхий 100 (нэг зуу) ортой
Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газрын
Барилга захиалагчийн хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



лтанд

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 28 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ДЭРГЭД
24X17.6М ХЭМЖЭЭТЭЙ, 9М ДИАМЕТРТЭЙ 4Ш ГЭР БҮХИЙ 100 (НЭГ ЗУУ)
ОРТОЙ МОНГОЛ ӨВ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫН ӨРГӨӨНИЙ БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, 6 дугаар цэцэрлэгийн дэргэд 24x17.6м хэмжээтэй, 9м диаметртэй 4ш гэр бүхий хүчин чадалтай 100 (нэг зуу) ортой Монгол өв уламжлал, ёс заншлын өргөөний барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхрын ангид 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр 9:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга О.Оджаргал
2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилга захиалагчийн хэлстийн хяналтын инженер Б.Мөнхзаяа
3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Н.Ёндонсамбуу
4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨАК, Техник хяналтын инженер Ц.Наранцацрал
6. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Дэд бүтэц төлөвлөлтийн газар Чанарын хяналтын хэлтсийн мэргэжилтэн Н.Болор-Эрдэнэ
7. Ус сувгийн удирдах газрын хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер Ө.Шинэцэцэг
8. Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төсөл хяналтын ахлах байцаагч Б.Даваасүрэн
9. Үндэсний Төв архив, зураг төслийн баримтын Архивын архивч Б.Оюунжаргал
10. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн Г.Уртнасан
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага,

хүртээмжийн үнэлгээний ажилтан
12.ЦМЖ дизайн консалтинг ХХК-ийн
Захирал
13. 6-р Цэцэрлэг эрхлэгч
14. Рино Инженеринг ХХК-ийн Ерөнхий Инженер

Н.Эрдэнэтөгс

Г. Цэнгэл
Ц.Дэлгэрмаа
Я.Нацагдорж

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, 6 дугаар цэцэрлэгийн дэргэд 24x17.6м хэмжээтэй, 9м диаметртэй 4ш гэр бүхий хүчин чадалтай 100 (нэг зуу) ортой Монгол өв уламжлал, ёс заншлын өргөөний барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн барилгын техникийн хяналтын Улсын байцаагч **Н.Ёндонсамбуу:**

- Бетоны лабораторын шинжилгээ үзүүлэх.
- Цэцэрлэгийн хашааг бүрэн дуусгах
- Тэмдэг тэмдэглэгээ хийх.
- Улаан журнал үзүүлэх.
- Зурагт тусгагдаагүй өндөржилт гарсан явган хүний зам тайлбар албан тоот өгөх
- Цэцэрлэгийн зүүн талын өндөржилттэй хэсэгт хамгаалалт хашлага хийх.
- Шилэн хийцэнд гарал үүслийн гэрчилгээ үзүүлэх
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа гаргаж өгөх
- Гэр анги руу зам хийх хэсгийн довжоонд тайлбар өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна бохир усны шугам худаг цэвэрлэх, дулаалгатай таг хийх
- Гадна цэвэр усны (гүний худагнаас оруулах) гүйцэтгэлийн зураг гаргаж цэвэр усны шугамын ашиглалтыг хэвийн болгох
- Узелийн өрөөнд халаагуур тавих
- Узелийн өрөөнд ус зайлуулах трап хийх тоноглолын хаягжуулалт зааварчилгааг байршуулах

- Нөөцийн савны ариутгал хийлгэх, шат угсрах.
- Хүүхдийн ариун цэврийн өрөөнд АС-н цахилгаан сорох сэнс зургийн дагуу угсрах
- Баруун хойд талын гэрийн халаалтын удирдлагын самбар бүрэн угсрах
- Хүнс хадгалах өрөөнд агаар сэлгэлт төлөвлөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Дэд бүтэц төлөвлөлтийн газар чанарын хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ**

- Дотор холбоо дохиоллын ил далд ажлын акт бүрдүүлэх
- Цомцог гэр доторх ил татагдсан сүлжээний утаснуудийг зурагт заагдсаны дагуу 16мм-н ган хоолойд сүвлэж хийх
- Сүлжээний утаснуудыг хаягжуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер **Ө.Шинэцэцэг:**

- Цэвэр усны нөөцийн савыг стандартын дагуу угсрах шат, түвшиний мэдрэгч, ус зайлуулах цооногоос мэдрэгчтэй насосоор БУШ-руу зайлуулах.
- Цэвэр усны нөөцийн савыг стандартын дагуу ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх
- Цэвэр усны өрөөнд халаах хэрэгсэл байрлуулах
- Цэвэр усны шинжилгээ өгөх
- Цэвэр усны системийг хэзээ, хэрхэн үндсэн цэцэрлэгийн гүний худгаас тэжээдэг болгох талаар албан тоотоор ирүүлэх
- Бохир усны цооног худгийг дулаалах
- Гүйцэтгэлийн зураг CD, ХМС-д өгсөн акт тус бүр 1% өгөх
- Жич: Автор нөөцийн савны зургийг бүрэн зурах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер **Ц.Наранцацрал:**

- 15/04158/22 техникийн нөхцөл (250кв чадалтай ктпн) дагуу холбо, сүлжээнд холбох залгах зөвшөөрөл авах (санал өгөх боломжгүй).
- 0.4кв шитний газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлж протокол авах
- Гал тогооны ерөнхий шитний болон гадна гэрэлтүүлгийн төмөр хийцлэлийг газардуулах хүрээтэй холбож холболт хийх.
- Гэрэлтүүлэг, газардуулга, аянгын ил далд ажлын акт, фото актыг нөхөж бүрдүүлж үзүүлэх.
- Давхарын шит, ерөнхий шит-нд хаягжуулалт, анхааруулах плакат хадах.
- Аянга хүлээн авагч хийх.
- Станцын холболт хийгдсэний дараа одоо холбогдсон байгаа тэжээлийг салгуулах

ХЯНАЛ

илга байгуу
оруу

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх газрын Барилгын зураг төсөл хяналтын ахлах байцаагч **Б.Даваасүрэн:**

- Цахилгаан ил явсан кабель утас ган хоолойгоор хийх
- Галын дохиоллын систем шалгасан акт фото зураг хавсаргах зааварчилгаа байрлуулах
- Цахилгааны шит гал унтраах автомат модулын систем төлөвлөх
- Галын краны холбох тотго хомут солих ус тавьж шалгах тэмдэглэгээ байрлуулах
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэсэн MNS5566:2020 стандартын дагуу.
- Гэр тус бүр разеткат гал тусгаарлах, дэмжидэггүй материал хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний Төв архив, архивч **Б.Оюунжаргал:**

- Архивд баримтаа баримт бүрдүүлэх жишиг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх
- Хувийн хэрэг бүрэн бүрдэлтэй жишиг жагсаалтын дагуу өгөх.
- Ажлын зураг болон өөрчлөлт гүйцэтгэлийн зураг жишиг жагсаалтын дагуу ажилж нүүр хуудас хянаж эх хувиар өгөх
- БУ-н тэмдэглэл дэвтэр эх хувиар баталгаажуулж өгөх
- Барилга угсралтын ил далд ажлын акт, гэрэл зураг эх хувиар өгөх.
- Барилгад хэрэглэсэн бараа материалын сертификат лабораторын шинжилгээний дүн гарал үүслийн гэрчилгээгээр хэрэг бүрдүүлж өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Барилга хөгжлийн төв, Норм нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **Г.Уртнасан**

- Гадна шат довжоонд хамгаалалт хашлага хийж өгөх
- Ус дулаан (цахилгаан) хангамжийг шийдвэрлэх
- УЗ-У2 тэнхэлэг дагуу бетон хаяавч хийх
- Гадна тохижилтын ажлын батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэх.
- БТХ-ийн 5.7.1-д заасны дагуу нормчлолын сангийн төлбөрийг төлөх
- Ашиглагч байгууллагад холбогдох баримт бичиг ,зураг төсөл хүлээлгэж өгөх хувийн хэрэг нээх
- Ус , дулаан хангамжийг биелүүлсэний дараа үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнэтөгс:**

ШАЛГА
ГАЗАР

уламжийн
улах ком

- Гадна явган хүний зам, талбай, бордюр унагаж сатандартын дагуу налуу болгох
- Ажилчдын ариун цэврийн өрөөнд ХБИ-стандарт тоног суулгах угаалтуур, суултуур мөн хүүхдийн ариун цэврийн өрөөнд батлагдсан зургийн дагуу хаалт болгон дээр түших бариул суулгаж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

ЦМЖ дизайн консалтинг ХХК-ийн Захирал **Г. Цэнгэл**:

- Ариун цэврийн өрөөнд зургийн дагуу тоноглол гүйцээж бүрэн суулгах
- Анги танхимд хийгдсэн ШХ-4-г зургийн дагуу онгойлтыг засаж суулгах
- Цахилгааны монтаж зургийн дагуу ган хоолой хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

6-р цэцэрлэг эрхлэгч **Ц. Дэлгэрмаа**:

- Тус цэцэрлэг нь гүний худагтай тул гүний худгаас усыг шууд татаж авдаг болгох
- Хүнс хадгалах өрөөнд агааржуулалт хийх
- Бохирын нүхний дотор талд нэмэлт таг хийх
- Зүүн талын хашаанд нэмэлт хамгаалалт хийх
- Ус зайлуулах хоолой хийх
- Усны нөөцийн саванд мэдрэгч хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч, Рино Инженеринг ХХК -ийн ерөнхий инженер **Я.Нацагдорж**

- Нийт гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, хяналтын инженер **Б.Мөнхзаяа**:

- Барилгын гадна цэргийн ангитай залгаа хэсгийг хаалт хашлага хийж гүйцэтгэх
- Цэцэрлэгийн барилгын гэрийн өндөрлөг хэсэгт хийгдсэн шат эко хавтан суугдсан хэсэгт хаалт метал хашлага хийж гүйцэтгэх
- Гал тогооны өрөөний агааржуулалтыг технологийн дагуу болгох
- Цахилгаан монтаж холбоо дохиоллын ажлыг зургийн дагуу хийж гүйцэтгэх
- Барилгын үндсэн ус хангамжийн системийг гүний худгаас барилга руу орох шугам холбож өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал**:

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих
- БТХ-ний дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор хүргүүлэх
- Батлагдсан зургийн дагуу тохижилт, ногоон байгууламж, налуу зам, шатны хамгаалалт гэх мэтийг хийж хэрэгжүүлэх

ЛТЫН

ашигла
СС

- Анги танхим аваарын гарц хаалганд ашигласан материал хатаалтай шил гэх мэт-д тайлбар албан тоот ирүүлэх (зохиогч, гүйцэтгэгч) MNS5830-2007 хаалга БА-ын хэсгийн тайлбар бичиг (БА)
- Зүүн талын газрын түвшинд (өндөржилт) зөрүү аюулгүй болгох хашлага хамгаалалт хийх
- Цахилгаан холболтын ажил мэдээллийг эцэслэн хянуулах холбогдох бичиг баримт бичиг
- Анги танхимуудын халаах хэрэгсэлд хамгаалалт хийх

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, 6 дугаар цэцэрлэгийн дэргэд 24x17.6м хэмжээтэй, 9м диаметртэй 4ш гэр бүхий хүчин чадалтай 100 (нэг зуу) ортой Монгол өв уламжлал, ёс заншлын өргөөний барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын,
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын
газар, Барилга захиалагчийн
хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

